

ОХУ-ЫН ГАДААД БОДЛОГО ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА*

С.Энхцэцэг*

Арван ес дүгээр зууны сүүл, хорь дунаар зууны эхээр олон улсын нөхцөл байдалд үүссэн түүхэн онцлог үйл явдлуудтай уялдан дипломат ажиллагааны чанар, арга барил ихээхэн өөрчлөгдөж хамрах хүрээ нь ч өргөжин тэлэх болсон байна. Дипломат ажиллагааг язгууртнууд голлон эрхэлж, зөвхөн тэдэнд заяагдсан онцгой эрх ямба мэтээр үзэж байсан бол XX зууны дунд үеэс эхлэн нийгмийн янз бүрийн давхрагаас мэдлэг боловсрол, авъяас чадвараараа шалгарсан мэргэжилтнүүдээс бүрдсэн томоохон алба гүйцэтгэх болжээ. Үүнээс үүдэн явцуу хүрээний, нууц үйлдлийн шинжтэй байсан үйл ажиллагаа нь аажмаар өөрчлөгдөн илүү чөлөөтэй, ил тод болсон байна.

Хүн төрөлхтний нийтлэг эрх ашгийг хөндсөн бэрхшээлтэй асуудлууд олширч, дэлхийн хэмжээнд эдийн засгийн интеграцийн үйл явц эрчимтэй өргөжиж, улс гүрнүүдийн харилцан шүтэлцээ, бие биеэс хамаарах хамаарал гүнзгийрч байгаа өнөөгийн нөхцөлд олон нийтийн дипломат ажиллагааны үүрэг урьд урьдаас эрс нэмэгдэх боллоо. Улмаар өнөө үед дипломат ажиллагаанд дипломат албаны мэргэжлийн хүмүүсээс гадна төрийн бусад албан хаагчид, эмэгтэйчүүд, шашны болон хүний эрхийн зэрэг олон нийтийн байгууллагын төлөөлөгчид, хувь хүмүүс идэвхтэй оролцож байгаа бөгөөд үүнийг ардын буюу олон нийтийн дипломат ажиллагаа хэмээх болжээ. Үүний зэрэгцээ гадаад бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхдээ олон нийтийн санаа сэтгэлийг харгалзан үзэх практик өргөжиж байна. Үндэсний дотоод зөвшилцөл нь гадаад бодлого бат туйлбартай байхын нэг

* Энэхүү өгүүллийг МУИС-ийн дэргэдэх Азийн Судалгааны Төвийн санхүүжилтийн хүрээнд бичив.

* МУИС, ОУХС-ийн магистр, докторант

чухал үндэс бөгөөд олон улсын зүгээс хүндэтгэлтэй хандах нөхцлийг бүрдүүлдэг хэмээн судлаачид үздэг. Тиймээс ч ихэнх улс орнууд гадаад хэргийн яамны хүрээнд олон нийттэй харилцах тусгай хэлтэс байгуулж хэвлэл мэдээллийн хүмүүс, нөлөөлөгч бүлгүүд, иргэдийн сайн дурын байгууллагын төлөөлөгчид, хувь хүмүүстэй харилцаж гадаад бодлогыг тайлбарлах, тэдний саналыг тусгах аргыг өргөн хэрэглэх боллоо.

Өнөөгийн глобал үйл явцыг зохицуулах үр ашигтай стратеги бодлого боловсруулахдаа иргэний нийгмийн төлөөлөл болох ажил хэргийн холбоотой байгууллагууд, мэргэжлийн холбоо, улс төр, нийгмийн хөдөлгөөнүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, шашны төлөөлөгчдийг өргөнөөр татан оролцуулах чухал нөхцөл бүрдэж байна. Ийнхүү дипломат ажиллагаанд оролцогчдын тоо нэмэгдэхийн хирээр түүний хамрах асуудлын хүрээ, хэмжээ ч тэлсээр байна. Уламжлалт дипломат алба голчлон улс төрийн асуудал эрхэлдэг байсан бол өнөө үед нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг олон төрлийн үйл явцыг зохицуулахад биечлэн оролцдог болжээ.

Энэ нөхцөлд дипломат алба, иргэний нийгэм хоорондын харилцаа холбоо, яриа хэлэлцээний механизмын ач холбогдол ихээхэн нэмэгдэж байна. Энэ харилцаа нь иргэдэд глобалчлалын үйл явцаас үүдэн улс оронд тулгамдаж буй асуудлууд, аз туршилт, боломжит зүйлсийн талаар төдийгүй олон улсын тавцанд явуулж буй дипломат үйл ажиллагааны явц, урт хугацаанд хэрэгжүүлэх зорилтын талаар бодит төсөөлөл өгөхөд нэн тустай юм. Нөгөө талаас, санал бодлоо солилцсоноор үндэсний эрх ашгаа гүн гүнзгий өргөн хүрээнд ухамсарлах, глобалчлалын үйл явцыг цаашид зохицуулах асуудлаар төрийн бус байгууллагын байр суурийг тусгах боломжтой юм.

1965 оноос эхлэн АНУ-ын Сенатын олон улсын харилцааны асуудал эрхэлсэн хэлтэс олон улсын болон соёлын хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулахдаа олон нийтийн дипломат ажиллагаа буюу Public Diplomacy хэмээх нэр томъёог анх хэрэглэжээ. Үүнд дурьдахдаа Public Diplomacy гэдэг нь гадаад бодлогын үзэл баримтлал, явуулж буй бодлогын үр дүнгийн талаар олон нийтийн санаа бодлыг судлах, түүнд эргээд нөлөөлөх явдал хэмээжээ. Энэ нь олон улсын хэмжээнд засгийн газрын нэр хүндийг өсгөх, хувийн байгууллага хоорондын харилцаа холбоо, улс орнуудын ашиг сонирхол, олон улсын харилцаанд өрнөж буй үйл явц, түүний гадаад бодлогод үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэх, харилцаа холбооны салбартай нягт харилцаатай байх (ялангуяа гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагатай), соёлын

арга хэмжээ, үйл ажиллагаа зэрэг олон улсын харилцааны томоохон хүрээг хамарсан өргөн хүрээтэй үйл явц юм.

Дипломат үйл ажиллагааг түүхэн хөгжлөөр нь: уламжлалт буюу сонгодог; ардын буюу олон нийтийн дипломат ажиллагаа хэмээн ангилдаг. Сонгодог дипломат ажиллагаа нь уламжлалт хэлбэр бөгөөд нууцлалыг дээд зэргээр эрхэмлэдэг учраас хаалттай хаалганы цаана явагддаг. Энэ нь олон улсын харилцааны нэн чухал асуудлаар хоёр болон олон талын хэмжээнд хэлэлцээ явуулахдаа олон нийтэд мэдээлэх, мэдээллийн хэрэгсэл нэвтрүүлэхийг хатуу хориглодог. Дипломатууд нууцлалыг хадгалахыг ихээхэн чармайдаг нь түүний гол онцлог юм. Тиймээс нууцлаг байх нь сонгодог дипломат бодлогын нэгэн салшгүй хэсэг ажээ.

Ардын буюу олон нийтийн дипломат ажиллагааг нэг талаар уламжлалт буюу сонгодог дипломат ажиллагааны орчин үеийн хэлбэр гэж үзэж болно. Дипломат гэрээ хэлэлцээр байгуулах уламжлалт арга барилаа хадгалж үлдсэн ч олон нийтэд бүрэн хаагдмал байдаг дипломат ажиллагааны нууцлалаа бүрэн алдаж байна. Үүнд нээлттэй гадаад бодлого явуулахыг уриалдаг либерал бодлого олон улсын харилцаанд зонхилох болсон нь ч хүчтэй нөлөөлжээ. Олон нийтийн дипломат ажиллагаа нь мэдээллийн хэрэгслийг ашиглан бодлогоо нээлттэй ил тод явуулах, харилцаа холбооны шинэ техник технологийг ашиглах, хувьсамтгай орчинд түргэн дасаж зохицох зэргээр ихээхэн ур чадвар шаардах болов.

Олон нийтийн дипломат ажиллагаа хэд хэдэн онцлогтой.

Нэгдүгээрт, олон нийтэд нээлттэй явагддаг.

Хоёрдугаарт, гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны талаар иргэдийг тодорхой мэдээллээр хангадаг, олон нийтийн саналыг бодлого боловсруулахдаа харгалзан үздэг, гадаад бодлогын үр дүнг тооцдог, эргээд шахалт үзүүлдэг төрийн бодлогын дотоод механизмын үүргийг гүйцэтгэдэг.

Гуравдугаарт, олон нийтийн дипломат бодлого нь гадаад бодлогыг хэрэгжүүлэх, сурталчлах, таниулах хэрэгсэл болдог.

Олон нийтийн дипломат ажиллагаа мэдээлэлжүүлэх, боловсрол, соёлын солилцооны хөтөлбөрүүд, олон улсын мэдээллийн хэрэгсэл гэсэн үндсэн чиглэлүүдээр голчлон үйл ажиллагаа явуулдаг. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевизийн хөтөлбөрүүд, радиогийн ярилцлага), сонин хэвлэл, лекц, чөлөөт ярилцлага, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллага, боловсролын

солилцоо, соёлын арга хэмжээ, үзэсгэлэн яармагийн үеэр зохиогдох хөтөлбөрт айлчлал зэрэг далайцтай аргуудыг ашиглан гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд олон нийтийн дипломат бодлогын ач холбогдол нэн чухал юм. Энэ бүхний эцсийн зорилт нь хилийн чанадад улс орныхоо нэр хүндийг өргөж, имижийг бүрдүүлэх явдал юм.

XXI зууны эхээр дипломат үйл ажиллагаа цоо шинэ шатанд гарлаа гэж үзэж болно. Мэдээлэл бол хамгийн үнэ цэнэтэй стратегийн нөөц гэж хэлж болохуйц томоохон хүчин зүйл болж хувирав. Үндэстэн дамнасан мэдээллийн хяналтгүй урсгал нь улс орны төдийгүй дэлхий нийтийн санаа бодолд гүн гүнзгий нөлөөлөх болсон. Мэдээллийн хэрэгслийн хүчтэй, өргөн хүрээг хамарсан үйл ажиллагаа, интернетийн дэлхийг хамарсан сүлжээнээс ангид байх аргагүй болж байна.

Нөлөө бүхий томоохон гүрнүүд үндэсний ашиг сонирхлоо хамгаалахаас илүү глобал хэмжээний мэдээллийн сүлжээнд /global info-sphere/ ноёрхохын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх болов. **Global info-sphere**¹ хэмээх глобал хэмжээний мэдээллийн хэрэгслүүд үйл ажиллагаа явуулдаг, олон нийтийн анхаарал төвлөрдөг томоохон хүрээ ч бүрэлдэж байна.

Эдгээр гадаад, дотоод хүчин зүйлүүдтэй уялдан Оросын дипломат үйл ажиллагаанд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байгааг ОХУ-ын судлаачид, улс төрчид онцлон тэмдэглэж байна.

Оросын гадаад бодлогыг түүхэн 3 үед хуваан авч үздэг. Үүнд:

1. Хаант Орос улсын гадаад бодлого;
2. ЗХУ-ын гадаад бодлого;
3. ОХУ-ын гадаад бодлого.

Эдгээр түүхэн үеийн онцлогуудаас товч дурьдвал хаант Оросын үзэл суртлын үндэс нь үндэсний оюун ухаан (ард түмэн), шашны сүсэг бишрэл (үнэн алдартны шашин), уламжлалт төрийн байгуулал (хэмжээгүй эрхт засаг)-ыг тунхагласан шинжтэй байв. Энэ томьёолол нь (үнэн алдартны шашин, хэмжээгүй эрхт засаг, ард түмэн) хаант Оросын улс төрийн амьдрал, нийгмийн байгууллын идеалист уриа лоозон, бодит агуулга болж байсан гэж үздэг.

ЗХУ-ын гадаад бодлого нь хэт үзэл сурталжсан, төвлөрсөн, ангич шинжтэй, төрийн монополь зонхилж байснаас гадна дипломат үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо тун бага байв.

¹ <http://www.ukpublicdiplomacy.org>

ОХУ үзэл сурталжиж, төрийн монополь зонхилсон гадаад бодлогоос татгалзаж прагматик, реалист байр суурийг баримтлахаа онцлон тэмдэглэж байна. Үндэсний ашиг сонирхлыг найдвартай хангах, эдийн засгийн бие даасан байдлыг бий болгох, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, үндсэн хуульт ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, иргэний нийгмийг эмхлэн байгуулах, иргэд, гадаад дахь нутаг нэгтнүүдийнхээ эрхийг хамгаалах зэрэг нь өнөөгийн ОХУ-ын гадаад бодлогын тэргүүний зорилт болон тавигдаж байна.

ОХУ олон улсын хамтын ажиллагаанд нилээд идэвхтэй оролцож олон улсын нөлөө бүхий байгууллага, институтэд гишүүнээр элсэв. Гол зорилго нь дэлхийн тавцанд Оросын байр суурийг бэхжүүлэх явдал юм. 1990-ээд оноос эхлэн гадаад худалдааны монопольчлол, соёл, шинжлэх ухаан, спортын төдийгүй хүмүүс хоорондын хэт үзэл сурталжсан хандлагаас татгалзаж, олон талт харилцааг чухалчлах болсноор гадаад харилцаа эрчимтэй хөгжиж байна. Энэ нь юуны өмнө Оросод өрнөж буй ардчилалтай холбоотой төдийгүй гадаад бодлого улам бүр нээлттэй болсноор парламент, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон бусад иргэний нийгмийн төлөөллүүд, хувиараа аж ахуй эрхлэх эздийн холбооны үүрэг ч улам бүр нэмэгдэж байна.

ОХУ-ын бүс нутаг, субъектууд бие даан гадаад улс орнуудтай харилцах нь нэн тустай явдал гэж үзэх болсон бөгөөд ялангуяа ТУХН-ийн орнууд, хил залгаа орших бусад улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх болжээ. Оросын гадаад бодлогод иргэний нийгмийн томоохон төлөөллийг хамарч чадах нийгэм, улс төр, соёл, шашны байгууллага, хөдөлгөөн, институтын үйл ажиллагаа багагүй үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь зөвхөн хэлбэршин тогтож буй цоо шинэ үзэгдэл боловч 2001 оны намар Москвад болсон иргэний форумын явц ихээхэн өргөн хүрээг хамарч буйг харуулсан юм.

ОХУ-д дипломат алба болон нэр хүндтэй төрийн бус байгууллага хоорондын үр бүтээлтэй, нээлттэй санал бодлоо чөлөөтэй солилцох явдал аль аль талдаа амин чухал ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрөх болжээ. Санал бодлоо харилцан солилцох энэхүү механизм нь чухал бөгөөд үүнийг өнөөгийн үүсээд буй нөхцөл байдал, дэлхий ертөнц бүхэлдээ шаардаж байна.

Оросын дипломат алба шашны сүм хийдтэй урт удаан хугацааны уламжлалт харилцаатай байжээ. Шашны сүм хийд дипломат алба залгуулж байсан түүхэн

туршлага ч бий. Дипломат үйл ажиллагаанд шашны гүйцэтгэх үүрэг ролийг тодорхой хэмжээгээр үнэлж, дэмжих болсон өнөө үед шашны байгууллага ялангуяа ТУХН, Балтийн улс орнуудад амьдардаг орос иргэдийн эрх, шашин шүтэх эрхийн асуудлаар, түүнчлэн Зөвлөлтийн дараахи орон эйд энхийг сахиулах зорилгоор дипломат байгууллагатай нягт хамтарч ажиллах болжээ. Түүний зэрэгцээ Ойрхи Дорнод, Палестины асуудлыг онцгойлон анхаарч дайныг зогсоож, шударга ёсыг тогтоох, энхийг сахиулахад хувь нэмэр оруулахыг зорьж байна.

Олон үндэстэн ястан бүхий Орос улсын хувьд шашин шүтлэгээ сэргээх явдал нь нийгмээ өөрчлөн байгуулах олон талт үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэг төдийгүй соёлын өвөрмөц байдлаа бататгаж буй явдал юм. Энэ нь хүчинд тулгуурлах бус өндөр ёс суртахууны зарчимд тулгуурлах ёстой гэж үздэгтэй холбоотой. Олон жилийн түүхэн туршлагатай, оюуны чадамж өндөртэй Оросын шашны үзэл санаа нь өнөөгийн дипломат ажилтнуудын үзэл санааг улам баяжуулж улс орныхоо үндэсний ашиг сонирхлыг гүн гүнзгий ухамсарлахад тус дөхөм болох юм. Дипломатууд, шашны зүтгэлтнүүдийн явуулж буй үйл ажиллагаа, арга барил нь ялгаатай ч эцсийн энхийг сахиулах нэг зорилт нь тэднийг нэгтгэж байдаг.

ОХУ-д шашны үзэл санаа нь орон нутгийн болон бүс нутгийн хямрал, зөрчилт мөргөлдөөнийг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой гэсэн үзэл санаа байдаг. Олон улсын хурал чуулганы үеэр ч, өдөр тутмын үйл ажиллагаандаа ч Оросын дипломат бодлого нь иргэдийн болон гадаад дахь эх орон нэгтнүүдийнхээ шашин шүтэх эрхийг хамгаалахад онцгой анхаардаг². Энэ хүрээнд Оросын ГХЯ Оросын үнэн алдартны сүм хийд, Оросын лал шашинтнуудын оюун санааны холбоо болон бусад шашны төлөөлөгчидтэй нягт холбоотой ажилладаг байна.

Дипломат алба, Оросын шашны байгууллагын хооронд голчлон аюулгүй, ардчилсан нийгэм байгуулах ёс суртахууны зарчмууд, энхийг сахиулхад шашны гүйцэтгэх үүрэг, шашны цөөнхүүдийн эрхийг хамгаалах асуудал, бусад ард түмний оюуны үнэт зүйлсийг хамгаалах, хүчирхийллийн асуудлаар хэлэлцэж санал бодлоо солилцдог³ байна.

Өнөөгийн глобалчлалын үйл явц нь ОХУ-ын гадаад бодлогын өмнө шинэ төвөгтэй асуудал үүсгэхийн хирээр шинэ боломж, нөхцлийг ч бий болгож байна.

² Митрополит Кирилл: "Русская православная церковь изначально имела свою внешнюю службу", *Международная жизнь* 2002 №6, стр.37

³ Игорь Иванов: "Новая Российская дипломатия: десять лет внешней политики страны" 2002г. Москва.стр 69

Оросын дипломат албаны олон жилийн туршлагаас үзвэл Орос улс ямар ч тохиолдолд идэвхгүй, тусгаарлагдмал гадаад бодлого явуулах боломжгүй байсан. Өөрөөр хэлбэр Оросын үндэсний ашиг сонирхол байнга идэвхтэй байж олон улсын тавцанд ямар нэг хэмжээнд систем бүрдүүлэгчийн үүрэг гүйцэтгэсээр иржээ. Улам бүр интеграцчилагдан нэгдэж буй өнөөгийн нөхцөлд гадаад бодлогын идэвхтэй үйл ажиллагаа улам бүр чухлаар тавигдаж байна гэдгийг ерөнхийлөгч В.В.Путин онцлон тэмдэглэжээ. Нийт хүн төрөлхтний ашиг сонирхлын үүднээс глобалчлалаас үүдэх сөрөг үр дагаврыг багасгаж үр шим, давуу талыг нь нэмэгдүүлэхийг уриалсан олон улсын харилцааны шинэ системийг бүрдүүлэхэд ОХУ томоохон үүрэг гүйцэтгэх боломжтой юм. Иймээс өнөөгийн ОХУ нээлттэй, прагматик, реалист бодлогыг чухалчилж түүнийгээ үндэсний ашиг сонирхол, өнөөгийн бодит боломжит нөхцөлд нийцүүлэхийг чухалчилж байна. Олон улын хэмжээнд гүйцэтгэх энэ үүргээ биелүүлэхийн тулд Орос улсын хувьд эдийн засгаа сэргээн хөгжүүлэх, ардчилсан үйл явцыг цаашид тогтворжуулах, гадаад бодлогын үндсэн зарчим, хүчин зүйлсийн талаар нийгэмд зөвшилцөл бүрдүүлэх үйлст олон нийтийн оролцоо нэн чухал болохыг онцлон тэмдэглэж байна.

Since the establishment of the Russian Federation the country adopted foreign policy concept and military doctrine in which aspects of public diplomacy has got concrete coverage. Russia is pursuing multi polar foreign policy. It is quite obvious that building democracy and establishing market oriented economic system is going take some time.

Russia became member of internationally recognized institutions in order to strengthen its position. Thanks to open policy of Russia role of local and business entities are increasing as well as other representatives of civil society. Russia is paying much more attention to spreading Russian language and culture.

It is officially recognized that fruitful cooperation between diplomatic service and renewed public organizations is very important. It is known that religion has played significant role in foreign policy of Russia since ancient time. Once Churches fulfilled a role of diplomatic missions. Role of churches are increasing in building secure, peaceful state. Much could be said about churches in preserving and preventing local conflicts and crises. With this view in mind foreign Ministry Russia is working closely with orthodox church and muslims representatives.

Globalization opens new perspectives for Russia at the same time creating difficulties and hurdles. Therefore Russian pragmatic and realist policy will be supported by public diplomacy.

Structure of the Russian Foreign Ministry has undergone changes, namely several departments were set up dealing with public diplomacy. Just to sum up the Russian public diplomacy is at embryo stage.